



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэнгэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын-IV байр
Утас: 76-04-37, Факс: 51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

2022.03.15 № 071602
танай _____ -ны № _____ -г

ДУЛААНЫ IV ЦАХИЛГААН СТАНЦ
ТӨХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
Ү.ТӨМӨРХУЯГ ТАНАА

Хараат бус аудиторын тайлан

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Дулааны IV цахилгаан станц ТӨХК-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Дулааны IV цахилгаан станц ТӨХК-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч компаниас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон зүйл

Дулааны IV цахилгаан станц ТӨХК нь Хөгжлийн Турбоагрегат 1,2,3,4-ийн шинэчлэлтэй холбоотойгоор 76.6 сая евро буюу 234,605.5 сая төгрөгийн зээл авсан байна. Урт хугацаат зээлийн эргэн төлөлт 11.4 сая евро буюу 30,180.4 сая төгрөг, зээлийн үлдэгдэл 75.1 сая евро буюу 241,907.9 сая төгрөг байна. 2021 онд төлөгдөх үндсэн зээл болон хүүгийн төлбөрөөс хугацаандаа төлөгдөөгүй үндсэн зээлийн төлбөр 7.3 сая евро буюу 23,502.1 сая төгрөг, хүүгийн төлбөр 1.7 сая евро буюу 5,540.6 сая төгрөг байна.

Хөгжлийн банкны зээлийн эргэн төлөлттэй холбоотойгоор Эрчим Хүчний Зохицуулах Хорооноос 2022 оны сүүлийн хагас жилд үнэ тарифт өөрчлөлт оруулж, зээлийн төлбөр төлөх эх үүсвэрийг шийдвэрлэхээр төлөвлөн ажиллаж байна.

Аудитын гол асуудлууд

Бидний мэргэжлийн шийдлийн дагуу аудитын гол асуудалд тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн их нөлөөтэй зүйлсийг тодруулах ба тэдгээрийг аудитын хүрээнд нэгтгэсэн байдлаар авч үзсэн болно.

001050955

Эрчим хүчний сайдын 2021 оны 9 дүгээр тушаалаар 2021 оны техник, эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд нийт орлогыг 280,782.7 сая төгрөгөөр, нийт зардлыг 297,369.8 сая төгрөгөөр, алдагдлыг 16,587.1 сая төгрөг байхаар баталсан байна. Эрчим хүчний сайдын 2021 оны 196 дугаар тушаалаар их завсар, техник зохион байгуулалтын арга хэмжээ, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг 935.0 сая төгрөгөөр бууруулж тодотгосон байна.

Гүйцэтгэлээр 348,222.2 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 329,207.7 сая төгрөгийн зардал гарган, 17,829.8 сая төгрөгийн ашигтай ажилласан байна.

Бусад мэдээлэл

Удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Компанийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд 7 зорилтын хүрээнд 7 арга хэмжээ төлөвлөж, гүйцэтгэл 93 хувьтай гэж тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдүүдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

 Ц.НАРАНЧИМЭГ